



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 1 өдөр

Дугаар 1/249

Мандалговь

Ариун цэврийн өрөөгөөр иргэд,  
жуулчид чөлөөтэй үйлчлүүлэх  
нөхцөл бүрдүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Эрүүл аюулгүй-Цэвэр орчин" бүрдүүлэх 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан аймаг, сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, үйлчилгээний байгууллагууд ариун цэврийн өрөөг үнэгүй, нээлттэй болгож, иргэд, жуулчдад чөлөөтэй үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэхийг үйлчилгээний бүх аж ахуйн нэгж, байгууллагын дарга, удирдлага, захирлуудад үүрэг болгосугай.
2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Н.Гантулга), сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100694